

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж бодлогын бичиг, тогтоомж	Төсө в	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн хэрэгжилт тайлбар/ түвшин буюу /хүрээгүй бол	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Зорилт 1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1	Арга хэмжээ1.1 Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Шаардлагагүй	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан болон НДЕГ-с ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал , чиглэлийн хэрэгжилтийг тухай бүр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг өгөх, орлогыг бүртгэж тэтгэвэр тэтгэмж бусад зардлуудыг олгосон.	100%

1.2.	Арга хэмжээ1.2 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах;	2918 .1сая	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна.	Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 2.470,3 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны 2025 оны төсвийн хуваарьт батлагдсан хагас жилийн 2.918,1 сая төгрөгнөөс хагас жилийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1.437,4 сая төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин төсвийн сахилга батыг ханган ажилласан.	100%
1.3.	Арга хэмжээ1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах;	15 сая	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 арга хэмжээ зохион байгуулсан.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай хуулийн дагуу даатгуулагч ажил олгогчдод зориулсан YOMШӨ-с урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн сургалтыг НДҮЗ-ийн 07 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалт явуулан шалгарсан “Эндээ хөгжил ТББ”-д холбогдох журмын дагуу 60 хувийн урьдчилгаа болох 9,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгон шийдвэрлэсэн.	100%

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 2: “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд

хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.1	Арга хэмжээ 2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 736.962,4 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн.	НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаал, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын даргын 2023 оны 05/2405 тоот албан бичгийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01 нээс эхлэн нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төв сангийн харилцах дансанд арилжааны банкууд бүрэн төвлөрүүлсэн. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өдөр бүр цахимаар төв төрийн сангийн гүйлгээнд 50 удаа 62.400,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. 2024 оны хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансны орлого 398.500,0 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлэн ажилласан.	100%
2.2.	Арга хэмжээ 2.2 Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. б) Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна. в) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны хагас жилийн байдлаарх 154,3 тэрбум төгрөгийн нийт зардал батлагдсан бөгөөд тэтгэврийн даатгалын сангаас давхардсан тоогоор 150036 тэтгэвэр авагчдад 138,5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас нийт 9865 даатгуулагчдад 9,1 тэрбум төгрөгийн тэтгэмж, ҮОМШӨ даатгалын сангаас 125 даатгуулагчдад 1,1 тэрбум	100%

					гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна.	төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 1024 даатгуулагчдад 5,5 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг шилжүүлэн хэлтсийн батлагдсан төлөвлөгөөний сарын хуваарьт багтаан хяналт тавин ажиллаж байна Хагас жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжинд 650,0 сая төгрөгийн зардал,ҮОМШӨ даатгалын сангийн ХЧТА тэтгэмжинд 250,0 сая төгрөг төсвийн хуваариас хэтрэхээр байгаа тул тооцооллыг хийн НДЕГ-т төсвийн тодотгол хийлгүүлэх саналаа 1 удаа хүргүүлсэн. Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийн тайлангийн хугацаанд бүрэн шилжүүлсэн.	
2.3.	Арга хэмжээ 2.3 Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.		Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.	Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан.	а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	Нийгмийн даатгалын үйл ажиллагааны жилийн 2.918,1 сая төгрөгийн төсвөөс хагас жилийн байдлаар 1.437,4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Дээрх батлагдсан 1.437,4 сая төгрөгийн урсгал зардлаас зарцуулагдаагүй үлдэгдэл 99.0 сая төгрөгийн сангийн яамны шийдвэрийн дагуу тайлант оны эцэст зарцуулахаар санхүүжилтийг хассан бөгөөд үлдсэн зардлыг төсвийн ангиллын дагуу зарцуулан хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцон өглөг авлага үүсгэхгүй	100%

						байх тал дээр анхааран ажиллаж байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтийн горим баримтлан өр авлага үүсгэхгүй байх тал дээр анхааран ажиллаж байна.	
2.4.	Арга хэмжээ 2.4 Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	Тус газрын нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сикос системээр бүрэн гаргаж сар бүр хүргүүлэн ажиллаж байна. Шинэ системээр 2024 оны сангийн санхүүгийн тайланг гарган Мэдээлэл тооцоолох төвөөс оны хаалтыг хийлгэсэн ба сангийн 2 дугаар улирлын тайлан гаргах бэлтгэл ажлын хүрээнд холбогдох бүртгэлийг тухай бүр хийн ажиллаж байна. Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан.	100%
2.5.	Арга хэмжээ 2.5 Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт,		Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран	-Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын	Үндсэн хөрөнгийн тооллогоорх тоон мэдээллийг төрийн өмчийн тооллогын нэгдсэн системд бүрэн бүртгэн баталгаажуулсан. Тус газрын Тооллогоор 547 ширхэг	

	хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах.		зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна.	зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; -Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; -Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх; -Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх; -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах; -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон	2.164.0 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг тоолон баталгаажуулж ажилтан албан хаагчдын картыг шинэчлэн коджуулж ажиллалаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 8.098,2 мян төгрөгийн 40 ширхэг хөрөнгийг актлах, ашиглалтын хугацааг сунгаж дахин үнэлэх 9.689.3 мян төгрөгийн 20 ширхэг хөрөнгийн жагсаалтыг гаргаж хүргүүлсэн. . Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн дагуу Капитрон банкинд 9.6 мкв талбайг түрээслүүлэх гэрээний дагуу 2024 оны түрээсийн гэрээний сунгалтын хүсэлтийн материалыг НДЕГ-р хүргүүлэн ажилласан. Хөрөнгийн тооллогын тоон баримт мэдээ тайланг НДЕГ-т хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.	100%
--	---	--	---	---	---	---	------

					орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах; -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна.		
2.6.	Арга хэмжээ 2.6 Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.		Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	а)Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.	Нийгмийн даатгалын байгууллага, сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг “Солид Юнити Аудит” ХХК хийж гүйцэтгэсэн ба байгууллагын тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн. Сангийн тайлангийн аудитыг нийслэлийн салбарын хэмжээнд түүвэр аудитад хамрагдан аудитын 1 зөвлөмж тавигдсан. Аудитаас өгсөн зөвлөмжийг залруулах болон цаашид үйл ажиллагаанд давтан гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж аудитын зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх төрийн аудитад хүргүүлсэн. Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн мөрөөр дараахь	100%

						ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: - Бараа материалын Sicos программд бараа материалын дэлгэрэнгүй болон хураангуй тайлан бэлтгэгдэн Нягтлан бодох бүртгэлийн Green системд программд үлдэгдэл нь зөв татагдан тайлан бэлтгэгдэж байгаа боловч бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээр эксель хэлбэрт дутуу хөрвөж байсан тул программ хангамж хариуцсан холбогдох байгууллагад уламжлан засуулж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан. - Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс зарлага гарах батлагдсан төсвийн гүйцэтгэлийн хуваарийн дагуу тооцон тухай бүр гүйлгээг тогтмол сар бүр мэдээлж байна. -Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгүүлэн цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг 2025 онд худалдан авах боломжоор хангагдсан.	
2.7.	Арга хэмжээ 2.7 Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх.		Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн,	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Банкуудтай байгуулсан 2024 оны “Хамтран ажиллах гэрээ”-ний биелэлттэй холбоотой зарим “хангалтгүй” хэрэгжсэн заалтыг цаашид залруулах, холбогдох саналаа НДЕГ-т хүргүүлэн 2025 оны хамтран ажиллах гэрээнд тусгуулсан. 2025 оны гэрээний хэрэгжилтийг дараа оны эхэнд	100%

			хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.			дүгнэх хамтран ажилдаг банкнууд болон холбогдох албан хаагчидтай уулзан гэрээгээ дүгнэн цаашид тусгагдах саналаа НДЕГ-т хүргүүлнэ.	
2.8.	Арга хэмжээ 2.8 Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Нийгмийн даатгалын цахим мэдээллийн санг өдөр бүр өөрийн серверт хуулан бүрдүүлж МТТ-д дамжуулж байна. Анхан шатны нягтлан бодох бүртгэлийн баримт бүрдүүлэлтийг үнэн зөв хуулийн дагуу бүрдүүлэх, бүртгэлийн алдаа залруулга гаргахгүй байх тал дээр анхааран ажиллаж нийгмийн даатгалын сангийн жилийн тайланг НДЕГ-т хянан баталгаажуулж мэдээллийн санд тогтоосон хугацаанд хаалт хийлгүүлсэн. 2024 оны санхүүгийн тайлангаар ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан.	100%
2.9.	Арга хэмжээ 2.9 Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.		ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	Шинэ системийн нэвтрэлттэй холбоотой хөгжүүлэлтийн заавар, даалгаврын дагуу тухай бүр хийж гүйцэтгэж холбогдох цахим сургалтуудад тухай бүр оролцсон. 2025 оны хагас жилийн тайлангийн бэлтгэл ажлын хүрээнд бүртгэл үүсэхгүй, алдаа заах , систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг	100%

			хийж гүйцэтгэнэ.			тухай бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Corg” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан.	
2.10.	Арга хэмжээ 2.10 Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	2024 оноос эхлэн санхүүгийн шинэ системд шилжсэнтэй холбоотойгоор барагдуулах боломжтой авлага өглөгийг барагдуулах залруулах, нэр тодорхойгүй залруулах боломжгүй гүйлгээнд Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулжсан. 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар 2024 оны өглөг, авлагыг бууруулах, тооцооны үлдэгдлийг сан тус бүрээр гарган эзэн холбогдогч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллана.	100%

Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

3.1.	Арга хэмжээ 3.1 Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг	-	- Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ.	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 87 хувийн гүйцэтгэлтэй байна.	Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Байгууллагын цахим мэдээллийн хуудсанд тавигдах санхүү бүртгэлийн хэлтэст хамаарах сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан холбогдох судалгаа мэдээллийг мэдээлэл байршуулах эрх бүхий албан	100%
------	---	---	---	--	--	--	------

	хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;					хаагчид тухай бүр хүргүүлэн ажилласан.	
3.2.	Арга хэмжээ 3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих;	-	- Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.	Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 100 хувьтай байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга. нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын дагуу газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэвтрэн мэдээлэл, хяналт тавих ажилтныг томилох тухай" тушаалаар томилогдсон албан хаагчид нь байгууллагын үйл ажиллагааны 20 төрлийн, Нийгмийн даатгалын сангийн 21 төрлийн мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүр, жил бүр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг хяналт шалгалтын тасгаас сар бүр тогтмол хяналт тавин ажиллаж байгаа ба газрын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээнд дүгнэгдэж байгаа болно.	90%
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах							
	Арга хэмжээ 4.2 Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал,		-Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг	Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд	Даатгуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж буй байдлыг түргэн шуурхай	

4.1.	өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;		газарт хүргүүлнэ. -Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 100%-тай хэрэгжсэн байна.	бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна.	зохион байгуулан ажиллаж байна. 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар ERP системээр 17 албан бичиг, 2 өргөдөл ирснээс 8 албан бичигт албан тоотоор хариу хүргүүлэн 9 албан бичигтэй танилцан өргөдлийг бүрэн шийдсэн. Able программаар НДЕГ-с ирүүлсэн 24 албан бичгийг хүлээн авч холбогдох шийдвэр, чиглэлийг тасгийн ажилтнуудад танилцуулах хуудсаар танилцуулан ажилласан. Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2-8 хоног байна. ERP системээр бичиг хэргийн бүртгэлийн зөрчил бүртгэгдээгүй болно.	100%
4.2	Арга хэмжээ 4.8 Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах;		-Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 75%-тай байв.	Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	НДЕГ-с ирүүлсэн 11 тушаал болон албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлт, СБД ЗДТГ-с ирүүлсэн 5 албан бичгийн хариуг цахимаар болон албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.	100%

Зорилт 4.2: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.2.1	Арга хэмжээ 4.2.1 Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах;	-	Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна.	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр нягтлан бодогч мэргэжилтнүүдийн өрөөг засварлан ажлын байрны эмх цэгцийг ханган ажилласан.	100%
4.2.2	Арга хэмжээ 4.2.2 Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;	-	Дуудлага алдалт 15%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна	Ирсэн дуудлага 26669, дуудлага алдалт дунджаар 23 % байна.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна.	Тус газрын санхүү бүртгэлтэй холбоотой мэдээлэл зөвлөгөөг иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) 14 хоног тутам сангийн нягтлан бодогч болон мэргэжилтнүүд ээлжлэн хариуг өгч байна. 2025 оны хагас жилийн байдлаар 1669 дуудлагыг хүлээн авч хариу мэдээллийг өгсөн.	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
	1	2	3	4	5	6	7
1	Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох;	Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. -Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна.	Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна	Үндэсний бичигт хөрвүүлэх	Албан хэрэг хөтлөх	Санхүү бүртгэлийн хэлтсийн 5 ажилтан монгол бичгийн сургалтанд хамрагдаж байна.	100%

2	Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авах шалгалтанд бэлтгэн эрх авах;	Танхимын болон цахимаар сургалтанд 1-ээс доошгүй сангийн мэргэжилтэн болон нягтлан бодогч хамрагдсан байна.		Зохион байгуулагдсан хугацаанд	Зохион байгуулагдсан хугацаанд	Үйл ажиллагааны нягтлан бодогч В.Чанцалдулам Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтыг өгсөн.	100%
3	Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах;	Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана.	-	Тухай бүр	Тухай бүр	Ахлах нягтлан бодогч Д.Золзаяа Удирдлагын академийн "Ахлах түшмэлийн багц сургалтанд суралцаж байна.	100%

Тайланг хянасан:

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

(огноо)

Тайлагнасан:
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

(албан тушаал)

(огноо)

Төсвийн шууд захирагч

.....

Б.ЭНХТӨР

(гарын үсэг)

Нэгжийн дарга

.....

Д.ЗОЛЗАЯА

(гарын үсэг)